

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 75

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17,500.0 мянган төгрөгийн цус болон шээсний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,730.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, бусад эх үүсвэрээс 55,950.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 30 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, нийт дүнгээр 90.1 хувиар биелүүлж, биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

0702900295

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	73,812.9	90,390.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	456,785.7	476,534.2
Нийт хөрөнгийн дүн	530,598.6	566,924.8
Нийт өр төлбөрийн дүн	-	68,158.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	530,598.6	498,766.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	530,598.6	566,924.8
Үйл ажиллагааны орлогын дүн	771,357.0	948,333.1
Үйл ажиллагааны зардлын дүн	705,162.3	980,165.2
Үйл ажиллагааны үр дүн	66,194.7	(31,832.1)
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	64,086.3	(31,832.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	466,512.3	530,598.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	466,512.3	530,598.6
Тайлант оны үр дүн	64,086.3	(31,832.1)
Эцсийн үлдэгдэл	530,598.6	498,766.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	759,173.1	842,659.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	714,517.3	864,668.9
Үйл ажиллагааны ЦМГ	44,655.8	(22,009.8)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(16,928.0)	(5,730.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	28,357.8	(27,739.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	28,357.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,357.8	618.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	730,815.3	870,398.9
Урсгал зардал	730,815.3	870,398.9
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	759,173.1	842,659.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	724,798.4	808,602.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,374.7	34,057.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000.0	-

Гурав. Аудитын илрүүлэлт:


Аудитын илрүүлэлт

Аудитаар 25,779.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Нийгмийн даатгалын тайланд 25,779.3 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 1,207.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,207.4 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 1,207.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

5.2 Албан шаардлага

1. Сэргээн засах эмчийн сул орон тоонд эмч томилон ажиллуулаагүй, эмч нарын илүү цагийг тооцохдоо нэмэгдэл хөлс болон урамшуулал, ур чадварын нэмэгдлийг оруулж тооцож байгаагаас илүү цагийн хөлс хэт өндөр гарч цалингийн зардал нэмэгдэж, гүйцэтгэлд суурилсан тогтолцооны зарчмаар ажиллаж буй эмнэлгийн бие даасан байдал, төсөв санхүүг бэхжүүлэхэд сөрөг үр дагавар үүсэж, үр дүнгүй зардал гарч байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.үр ашигтай байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2022 оны 1а/1670 тоотод заасан "Дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал, урамшуулал, ур чадварын нэмэгдлийг оруулахгүй байхаар тооцох" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан илүү цагийн хөлсийг хууль тогтоомжийн хүрээнд олгох албан шаардлага хүргүүлсэн.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	1	25.8	1	25.8	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	25.8	1	25.8	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	2	1.2	1	1.2	1	-	-	-	-	-	-	-
Дүн	2	1.2	1	1.2	1	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
-Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	1	6.5	-	-	1	6.5	-	-
Дүн	1	6.5	-	-	1	6.5	-	-
Нийт дүн	1	6.5	-	-	1	6.5	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			